



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/123

Шивээговь сум

Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, 29.1.6.л, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны А/71 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Ч.Сугармаа (Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	Д.Отгонбаатар (Малын үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
Гишүүд:	Д.Отгонжаргал (Засаг даргын Тамгын газрын дарга)
	Н.Амаржаргал (1 дүгээр багийн Засаг дарга)
	С.Отгонбаатар (2 дугаар багийн Засаг дарга)
	Ш.Чинболд (Илчлэг-Шивээ орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал)
	Х.Сувданцэцэг (Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Энхриймаа (3 дугаар сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Даваадолгор (3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)

Г.Бямбасүрэн (БНЗӨБЦТС-ТӨХК-ийн Говьсүмбэр дэх салбарын Хэсгийн мастер)

Э.Төрмандах (Соёлын төвийн дарга)

Б.Шинэбаяр (Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч)

2. Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг чанартай зохион байгуулж, аж ахуйн нэгж, албан байгууллага, баг, хөдөөгийн малчин өрх тус бүрээр өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулан биелэлтэнд нь хяналт тавьж, ажлын тайлан, хэрэгжилтийн явцыг хугацаанд нь тайлагнахыг ажлын хэсгийн дарга /Ч.Сугармаа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ